



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/877

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тогтвортой хөгжлийн төлөөх үйл хэрэгт хүүхдийн манлайлал идэвхтэй оролцоог хангах зорилгоор зохион байгуулагдаж буй “Хүүхдэд ээлтэй - Ховд” чуулганы үйл ажиллагааны зардалд 13,000,000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 13,000,000 (арван гурван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.1-т тусгагдсан Боловсролын салбарын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний “Тогтвортой хөгжлийн боволсрол” хөтөлбөр, төслөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батнасан), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Х.БАТБОЛД



8400001 2184

Zah A/877 Ba

Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 04-ний өдрийн
А/877 дугаар захирамжийн хавсралт



ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ - ХОВД ХҮҮХДИЙН
ЧУУЛГАНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Төсөв	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Өдрийн хоол, цайны завсарлага	Хүүхэд	350	25,000	8,750,000
2	Нөлөөллийн контентын зардал видео	ш	5	500,000	2,500,000
3	Зураг угаах	Хүүхэд	350	5,000	1,750,000
Нийт дүн					13,000,000

-oOo-